



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.03.17 № 01/267  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“ХӨВСГӨЛ УС СУВАГ” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ П.ЛХАГВАЖАВ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөвсгөл ус суваг ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хөвсгөл ус суваг ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон зүйл**

Аудитын тайланд онцолсон асуудлыг бүрэн тайлбарласан харгалзах тодруулгыг санхүүгийн тайлангийн тодруулгууд болон нэмэлт толилуулгаас үзэж болох бөгөөд онцолсон асуудалтай холбоотой аудиторын дүгнэлтийг өөрчлөөгүй болно.

Коронавируст халдвар /ковид-19/ цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай 2021 оны 211 дүгээр тогтоолын дагуу 1980 айл өрх, 157 аж ахуйн нэгж байгууллагад цэвэр бохир усны үнэ, 6155 өрхөд ус түгээх байрнаас ундны цэвэр усаар үйлчилсний үнийг төрөөс хөнгөлөлт үзүүлсэн байна.

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Засаглах эрх бүхий этгээд болох компанийн ТУЗ-ын шийдвэрлэсэн авлага хүчингүй болгосон асуудлыг тайланд тусгасан болно.

**Бусад асуудал**

Аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй, санхүүгийн тайлангийн аудит, аудитын тайлантай холбоотой аудиторын хүлээх үүрэг хариуцлагын тухай дэлгэрэнгүй тайлбар өгөхөөр хууль тогтоомжоор шаардсан мэдээлэл байхгүй болно.

#### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас албан ёсны зөвшөөрөл ирээгүй тул Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр Мөрөн суманд баригдсан цэвэрлэх байгууламжийн барилгыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж аваагүй болно.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



**2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Хөрөнгө</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	87,580,127.08	205,481,477.45
1.1.2	Дансны авлага	388,205,566.69	277,784,824.26
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	1,157,896.58	0.00
1.1.6	Бараа материал	361,459,384.23	340,242,348.47
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>838,402,974.28</b>	<b>823,508,650.18</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	11,854,375,400.10	12,145,961,894.55
1.2.2	Биет бус хөрөнгө	3,653,237,301.85	3,634,669,034.56
1.2.9	Дуусаагүй барилга	7,037,344,488.48	7,394,880,829.56
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>15,504,612,702.00</b>	<b>15,780,630,929.12</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>16,343,015,676.59</b>	<b>16,604,139,579.29</b>
2.1.1.1	Дансны өглөг	6,835,831.92	62,934,408.60
2.1.1.3	Татварын өр	68,232,414.86	16,231,091.52
2.1.1.4	НДШ - ийн өглөг	0.00	326,223.82
2.1.1.6	Хүүний өглөг	475,910,478.40	544,149,712.46
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	290,000.00	478,792.00
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>551,268,725.18</b>	<b>624,120,228.40</b>
2.1.2.1	Урт хугацаат зээл	8,914,636,069.32	9,272,172,410.09
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>8,914,636,069.32</b>	<b>9,272,172,410.09</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>9,465,904,794.50</b>	<b>9,896,292,638.49</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	<b>2,245,880,669.67</b>	<b>2,245,880,669.67</b>
2.3.1	төрийн	2,245,880,669.67	2,245,880,669.67
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	657,840,694.47	657,840,694.47
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	5,379,472,310.36	5,321,717,899.70
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-1,406,082,792.41	-1,517,592,323.04
2.3.9.1	Тайлант үеийн ашиг /алдагдал/	-14,508,015.93	17,570,694.91
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг /алдагдал/	-1,391,574,776.48	-1,406,082,792.41
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>6,877,110,882.09</b>	<b>6,707,846,940.80</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>16,343,015,676.59</b>	<b>16,604,139,579.29</b>

**2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан**

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,110,788,693.46	2,653,258,764.10
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,966,593,641.25	2,415,278,066.70
<b>3</b>	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>144,195,052.21</b>	<b>237,980,697.40</b>
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	0.00	0.00
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	0.00	0.00

“Хөвсгөл ус суваг” ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	158,703,068.14	188,520,555.99
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	11,639,908.25
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	-17,003,915.68
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг ( алдагдал)	0.00	0.00
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>-14,508,015.93</b>	<b>20,816,317.48</b>
19	Орлогын татварын зардал	0.00	3,245,622.57
<b>20</b>	<b>Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>-14,508,015.93</b>	<b>17,570,694.91</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>-14,508,015.93</b>	<b>17,570,694.91</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
<b>24</b>	<b>Нийт дэлгэрэнгүй орлогын дүн</b>	<b>-14,508,015.93</b>	<b>17,570,694.91</b>
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,245,880,669.67	657,840,694.47	3,774,087,845.3	1,391,574,776.48	5,286,234,432.96
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.	0.	0.	0.	0.
3	Залруулсан үлдэгдэл	2,245,880,669.67	657,840,694.47	3,774,087,845.3	1,391,574,776.48	5,286,234,432.96
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.	0.	0.	-14,508,015.93	-14,508,015.93
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0.	0.	0.	0.	0.
6	Өмчид гарсан өөрчлөлт	0.	0.	1,605,384,465.06	0.	1,605,384,465.06
7	Зарласан ногдол ашиг	0.	0.	0.	0.	0.
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.	0.	0.	0.	0.

“Хөвсгөл ус сувар” ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

9	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,245,880,669.67	657,840,694.47	5,379,472,310.36	1,406,082,792.41	6,877,110,882.09
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.	0.	0.	0.	0.
11	Залруулсан үлдэгдэл	2,245,880,669.67	657,840,694.47	5,379,472,310.36	1,406,082,792.41	6,877,110,882.09
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.	0.	0.	17,570,694.91	17,570,694.91
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.	0.	0.	0.	0.
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.	0.	-57,754,410.66	-129,080,225.54	-186,834,636.2
15	Зарласан ногдол ашиг	0.	0.	0.	0.	0.
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.	0.	0.	0.	0.
17	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,245,880,669.67	657,840,694.47	5,321,717,899.7	1,517,592,323.04	6,707,846,940.8

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн	2,125,095,428.51	3,148,921,521.05
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,480,568,975.56	2,787,932,311.03
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	318,800,000.00	308,800,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	325,726,452.95	52,189,210.02
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,149,395,795.82	2,794,745,926.59
1.2.1	Ажиллагчдад төлсөн	994,469,742.00	1,215,654,186.17
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	252,119,650.38	216,719,932.45
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	391,560,710.00	411,872,753.91
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	167,116,680.50	200,855,791.87
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	95,452,751.00	128,697,693.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	173,153,679.99	376,675,538.20
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	771,975.00	7,689,820.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	74,750,606.95	236,580,210.99
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-24,300,367.31	354,175,594.46
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн	0.00	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0.00	0.00
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.1.8		0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн	50,000,000.00	236,274,244.09
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	20,000,000.00	236,274,244.09
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	30,000,000.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00

“Хөвсгөл ус суваг” ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.2.6		0.00	0.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-50,000,000.00</b>	<b>-236,274,244.09</b>
<b>3</b>	<b>Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>4.1</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-74,300,367.31</b>	<b>117,901,350.37</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>161,880,494.39</b>	<b>87,580,127.08</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>87,580,127.08</b>	<b>205,481,477.45</b>

**2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

мянган төгрөг

№	Эдийн засгийн ангилал	2020 оны гүйцэтгэл	Тайлант оны			
			Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>2,110,788.68</b>	<b>2,564,451.27</b>	<b>2,653,258.76</b>	<b>(88,807.49)</b>	<b>103.46</b>
1.1	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	289,818.18	280,727.27	280,727.27	-	100.00
1.2	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,820,970.50	2,283,724.00	2,372,531.49	(88,807.49)	103.89
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>2,125,296.70</b>	<b>2,564,112.10</b>	<b>2,603,798.60</b>	<b>(39,686.50)</b>	<b>101.55</b>
2.1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,137,411.50	1,258,060.4	1,268,136.6	-10076.2	100.80
2.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	145,815.50	173,465.2	166,869.5	6,595.70	96.20
2.3	Албан томилолт	5,042.60	6,480.0	1,350.5	5,129.50	20.84
2.4	Шуудан холбоо, хэвлэл захиалга	4,557.50	7,502.0	7,984.7	(482.70)	106.43
2.5	Бичиг хэрэг	5,092.20	4,950.8	9,091.2	(4,140.40)	183.63
2.6	Зар сурталчилгаа	129.50	2,000.0	4,204.0	(2,204.00)	210.20
2.7	Хөдлмөр хамгаалал	7,579.60	13,705.7	12,707.4	998.30	92.72
2.8	Нормын сүү	4,179.04	13,367.4	10,008.9	3,358.50	74.88
2.9	ХХХувцас хэрэгсэл /өвөл, зуны/	21,429.70	61,260.0	16,316.9	44,943.10	26.64
2.10	Газар ус ашигласны төлбөр	5,484.00	4,500.0	4,517.4	(17.40)	100.39
2.11	Түлш шатахуун	101,546.30	97,036.0	89,919.8	7,116.20	92.67

"Хөвсгөл ус суваг" ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.12	Бүх төрлийн даатгалууд	5,500.00	5,500.0	5,318.0	182.00	96.69
2.13	Сургалт	825.00	4,540.0	1,405.8	3,134.20	30.96
2.14	Үндсэн хөрөнгийн элэгдэл	187,537.70	247,608.3	219,389.8	28,218.50	88.60
2.15	Болзошгүй гамшиг	939.40	5,000.0	5,000.0	-	100.00
2.16	Ариутгал цэвэрлэгээ	7,851.80	15,611.2	14,159.5	1,451.70	90.70
2.17	Шинжилгээ	1,008.00	5,720.0	1,402.3	4,317.70	24.52
2.18	Цэвэрлэх байгууламжийн химийн бодис	-	327.9	-	327.90	-
2.19	Засвар үйлчилгээний зардал	85,247.30	53,927.00	123,754.70	(69,827.70)	229.49
2.20	Цахилгаан	148,403.00	185,702.3	176,048.7	9,653.60	94.80
2.21	Халаалт	12,055.60	19,620.1	21,429.0	(1,808.90)	109.22
2.22	Түлээ	28,866.20	25,180.9	23,324.6	1,856.30	92.63
2.23	Нүүрс	97,414.00	158,335.0	197,961.3	(39,626.30)	125.03
2.24	НСАХ шагнал	10,749.80	28,286.1	15,537.0	12,749.10	54.93
2.25	Жолоочийн хариуцлагын даатгал	-	1,152.9	1,152.9	-	100.00
2.26	Үл хөдлөх хөрөнгийн татвар	4,168.00	9,155.5	9,155.5	-	100.00
2.27	Тээврийн хэрэгслийн татвар	151.50	1,312.2	240.9	1,071.30	18.36
2.28	Газрын төлбөр	8,462.40	7,243.3	8,894.4	(1,651.10)	122.79
2.29	Найдваргүй авлагын зардал	-	10,000.0	54,869.3	(44,869.30)	548.69
2.30	Гадны байгууллагын хөлс	14,345.70	27,067.2	15,199.6	11,867.60	56.16
2.31	ТУЗ-ын зардал	33,298.20	35,050.0	36,018.5	(968.50)	102.76
2.32	Бусад зардал	40,205.66	75,444.7	82,429.9	(6,985.20)	109.26

**3. Санхүүгийн тайлангийн тодруулга**

**3.1 Байгууллагын үйл ажиллагаа**

Тус компани нь 100 хувь орон нутгийн өмчит компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэрэгжүүлнэ. Компанийн дүрэм нь Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн 105 дугаар тогтоолоор батлагдсан байна.

Компанийн үндсэн зорилт хэрэглэгчдийн дулааны эрчим хүчээр хангах, гүний усыг олборлон эрүүл ахуйн стандартад тохирсон цэвэр ус түгээх, бохир усыг татан технологийн дагуу зайлуулж цэвэрлэх, хэрэглээний халуун усаар хангах, халуун усны үйлчилгээгээр тогтмол найдвартай хангаж, ашгийн төлөө ажиллахад оршино. Компани нь энэхүү дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх зорилгоор дор дурдсан үйл ажиллагааг эрхэлнэ.

- Дулаан үйлдвэрлэн түгээх, нийтийн зориулалттай хувийн орон сууцанд амьдардаг айл өрхөд халаалт дулаан, сантехникийн засвар үйлчилгээг дуудлагаар хийх, цэвэр ус олборлон хэрэглэгчдэд хүргэх, халуун ус, бохир ус татан зайлуулах, айл өрх, албан байгууллагын халуун, хүйтэн усыг тогтворжуулах зэрэг түүнд нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх явдал юм.
- Компанийн хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа явуулах тухай шийдвэрийг Төлөөлөн Удирдах Зөвлөл гаргана.

- Компани нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардах үйл ажиллагаа явуулах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлсэний дараа тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.
- Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр өөрчлөн байгуулах, хувьчлах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд компани нь үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулна.

### 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Хөвсгөл ус суваг” хязгаарлагдмал хариуцлагатай компани нь 2016 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 56 дугаар тогтоолыг үндэслэн байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлд “Орон нутгийн өмчийн талаархи иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх: ... 4/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Аймгийн ИТХТ томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 4, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалтыг тус тус үндэслэж байгаа нь хуульд нийцэж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь сард 0.2 сая төгрөгийн цалинг тооцож олгодог. 2021 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн зардалд 35.0 сая төгрөг төлөвлөж, 36.0 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасны дагуу Гүйцэтгэх захирлын тушаалаар “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам”-ыг баталж, өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын төлөвлөгөөг гарган, мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол шийдвэрийн биелэлтийг тухай бүр хүргүүлэн ажилласан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу албан томилолтын зардлаас 5.1 сая төгрөг, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл 44.9 сая төгрөг, сургалтын зардал 3.1 сая төгрөг, усны шинжилгээ 4.3 сая төгрөг, нийгэм соёлын арга хэмжээний зардлаас 12.7 сая төгрөг хэмнэсэн байна. Зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зүйл хэвлүүлэхэд зардал гаргаагүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн Газрын 2021 оны 207 дугаар тогтоол “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай”
- Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”
- “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

“Хөвсгөл ус суваг” ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

- Ковид-19 цар тахалтай тэмцэх зорилгоор Засгийн газар, улсын аймгийн онцгой комиссоос гаргасан шийдвэрүүд
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа болон ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Тус компанийн санхүүгийн байдлын, орлого, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мян төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	87,580.1	205,481.4	117,901.3
Авлага	389,363.4	277,784.8	-111,578.6
Бараа материал	361,459.3	340,242.3	21,217.0
Үндсэн хөрөнгө	11,851,375.4	12,145,961.9	291,586.5
Биет бус хөрөнгө	3,653,237.3	3,634,669.0	-18,568.3
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>16,343,015.6</b>	<b>16,604,139.5</b>	<b>261,123.9</b>
Богино хугацаат өглөг	551,268.7	624,120.2	72,851.5
Урт хугацаат өглөг	8,914,636.0	9,272,172.4	357,536.4
Эздийн өмч	6,877,110.8	6,707,846.9	-169,263.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>16,343,015.6</b>	<b>16,604,139.5</b>	<b>261,123.90</b>

Тус компани нь Төрийн банк, Хаан банк, Хас банкинд харилцах данстай ба харилцах дансны үлдэгдэл 205.4 сая төгрөг байна.

Авлага дансны үлдэгдэл буурсан нь нийт авлагаас барагдах боломжгүй насжилт өндөртэй 2016 онд гурван компаниас шилжиж ирсэн 59.7 сая төгрөгийн авлагыг ТУЗ-ийн 2021 оны 26 дугаар тогтоол, Хөвсгөл аймгийн прокурорын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 01 дүгээр тогтоолыг үндэслэн найдваргүй болгосонтой холбоотой. Мөн өмнөх оны авлагаас 165.5 сая төгрөгийг бууруулж ажилласан байна. Одоо байгаа 277.7 сая төгрөгийн авлагаас 207.3 сая төгрөг нь 2021 оны 11, 12-р сарын төрөөс хариуцах цэвэр, бохир усны хөнгөлөлт он дамжиж орсонтой холбоотой үүссэн. Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 277.7 сая төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 340.2 сая төгрөг болж 21.2 сая төгрөгөөр буурсан нь хангамжийн материал сэлбэг хэрэгслийн үлдэгдэл буурсанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данс нь 291.6 сая төгрөгөөр нэмэгдсэн ба Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор цаашид ашиглах боломжгүй болсон 336.4 сая төгрөгийн хөрөнгийг акталсан Азийн хөгжлийн банкны зээлээр баригдсан цэвэрлэх байгууламжийн 357.5 сая төгрөгийн зөрүүг нэмсэнээс болжээ.

Богино хугацаат болон урт хугацаат өр төлбөр нэмэгдсэн нь Төрийн аудитаас хийсэн гүйцэтгэлийн аудитын шалгалтын зөвлөмжийн дагуу 2020 онд Азийн хөгжлийн банкны зээлээр баригдсан цэвэрлэх байгууламжийн зээлийн валютын ханшийн зөрүү болон зээлийг хүүгийн өглөгийг залруулсантай холбоотой үүсчээ.

**"Хөвсгөл ус суваг" ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Урт хугацаат өр төлбөр Азийн хөгжлийн банкны зээлээр баригдсан цэвэрлэх байгууламжийн 357.5 сая төгрөгийн өрөөр нэмэгдсэн байна.

**3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Хөвсгөл ус суваг ХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар тогтоолоор 2021 оны бизнес төлөвлөгөөг баталсан байна. Тус төлөвлөгөөнд 2,564.4 сая төгрөгийн орлого олж, 2,564.1 сая төгрөгийн зардал гарган 0,3 сая төгрөгийн ашигтай ажиллана гэж тусгажээ.

Хөвсгөл ус суваг ХХК-ийн 2021 оны зорилтот түвшний гүйцэтгэлээр 2,653.2 сая төгрөгийн орлого олж 2,632.4 сая төгрөгийн зардал гарган татвар төлөхийн өмнөх ашиг нь 20.8 сая төгрөгийн ашигтай ажиллажээ. Засвар үйлчилгээний зардлын хэтрэлт нь өмнөх оны ашиглалтанд байгаа материал, сэлбэг хэрэгслийн үлдэгдэлийг зарцуулсантай холбоотой гарсан байна.

*Хүснэгт 2 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин*

*/мян.төг/*

№	Үзүүлэлт	хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Үйлдвэрлэсэн цэвэр бохир ус	м3	171,378	196,333	188,616.00	96.07
2	Зайлуулсан бохир ус	м3	134,215	189,817	161,117.00	84.88
3	Гэр хорооллын цэвэр ус	м3	74,891	80,891	82,242.00	101.67
4	Үйлдвэрлэсэн дулаан	М3	30,239	52,548	52,548.00	100.00
5	Халуун усны үйлчилгээ	хүн	40,470	75,132	26,443.00	35.20
6	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>мян/төг</b>	<b>2,110,788.68</b>	<b>2,564,451.27</b>	<b>2,653,258.76</b>	<b>103.46</b>
	Үндсэн үйл ажиллагаанаас	мян/төг	1,820,970.50	2,283,724.00	2,372,531.49	103.89
	Орон нутгийн төсвөөс	мян/төг	289,818.18	280,727.27	280,727.27	100.00
5	<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>мян/төг</b>	<b>2,125,296.70</b>	<b>2,564,112.10</b>	<b>2,632,442.44</b>	<b>101.55</b>
6	Татварын өмнөх ашиг	мян/төг	-14,508.0	339.2	20,816.3	
7	Цэвэр ашиг /алдагдал/	мян/төг			17,570.6	

**4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу "Хөвсгөл ус суваг" ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад авлагын данс, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25 -наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Бизкон Аудит ХХК-ийн Хөвсгөл салбарын ахлах аудитор Ч.Мөнхбаяр, аудитор Д.Эрдэнэжаргал нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл ус суваг ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Бизкон Аудит ХХК-ийн Хөвсгөл салбарт 2022 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн 20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Дотоод хяналт**

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Компанид дотоод аудитор байхгүй тул дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах боломжгүй байна. Дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын нэгжээс болон ТУЗ-ын аудитын хороо хэрэгжүүлэх ёстой бөгөөд тайлант онд дотоод аудитыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

#### **4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

"Хөвсгөл ус суваг" ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

#### **4.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлого, Санхүүгийн байдлын тайлангийн цэвэр хөрөнгийн дүн болох 6,877.1 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 34.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 24.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Тайлант 2021 оны санхүүгийн тайлангийн цэвэр хөрөнгийн дүн 6,707.8 сая төгрөгөөс 0.5 хувь буюу 33.5 сая төгрөгөөр гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 70 хувиар буюу 23.4 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

### **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 9 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх 75 мэдээллээс 64 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Үүнд: Хуулийн /6.8.1 Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, бусад санхүүгийн хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ концесс, засгийн газар, орон нутгийн баталгаат, төсвийн өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн мэдээлэл, 6.4.4 Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл/-ийн 945.6 сая төгрөгийн мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлээгүй хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах мэдээ, мэдээллийг байршуулахдаа хуульд заасан хугацаанд байршуулж ажиллах "Зөвлөмж" хүргүүлэхээр шийдвэрлэв.

## **5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулинд заасан хугацаанд нийцээгүй бөгөөд 64 мэдээ мэдээллийг хугацаа хоцроосон, ТБОНӨХБАУХА тухай хуулийн хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан нь хуулийн шаардлагад нийцсэн байна гэж дүгнэлээ.

## **6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Завсрын аудит хийгдээгүй бөгөөд гүйцэтгэлийн аудитаар 753.0 сая төгрөгийн зөрчил илэрч 750.8 сая төгрөгийн зөрчилд 20 зөвлөмж, 1 албан шаардлага, 2.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосон байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснөөс зөвлөмж 80 хувийн биелэлттэй байна.

## **7. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дуусаагүй барилга дансны үлдэгдэл нь 7,394.9 сая төгрөг болж өмнөх оноос өөрчлөгдөөгүй 357.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь 2020 оноос хойш дуусаагүй барилга дансанд бүртгэгдсэн цэвэрлэх байгууламжийн барилга байгууламж дансанд тусгаж ажиллаагүй байна. Цэвэрлэх байгууламжийн зохих бичиг баримтыг бүрдүүлж үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж тайлагнах шаардлагатай байна.

## **8. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 105.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 90.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, Шилэн дансны хуулийн хэрэгжилт болон авлагын тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 14.8 сая төгрөгийн алдаа нь материаллаг боловч тогтоосон материаллаг түвшинээс бага байгаа тул "Зөрчилгүй" дүгнэлт өглөө.

### **8.1 Залруулсан алдаа**

Мөнгөн гүйлгээний тайлан дахь үндсэн хөрөнгө худалдан авахад гарсан зарлага 236.3 сая төгрөг байхад санхүүгийн тайлангийн тодруулга тайлангаар 326.9 сая төгрөг гэж бараа материал худалдан авсан зарлагыг буруу тайлагнасныг залруулах бичилт хийсэн.

### **8.2 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### 8.3 Албан шаардлага

Албан шаардлага тогтоогоогүй

### 8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. *Балансын данстай холбоотой асуудал*

Илрүүлэлт:

Тайлант онд 277.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй бөгөөд хугацаа хэтэрсэн авлага байхгүй байна. Байгууллага иргэдээс авах 14.8 сая төгрөгийн авлагыг тооцооны үлдэгдлээр баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалттай нийцээгүй ба эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Холбогдох байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулах арга хэмжээ авах.

#### 2. *Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал*

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх 75 мэдээллээс 64 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Хуулийн /6.8.1 Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, бусад санхүүгийн хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ концесс, засгийн газар, орон нутгийн баталгаат, төсвийн өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн мэдээлэл, 6.4.8 .... Авлага үүсгэсэн шийдвэрийн тоол-ийн 945.6 сая төгрөгийн 64 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлээгүй хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн (6.8.1 Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, бусад санхүүгийн хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ концесс, засгийн газар, орон нутгийн баталгаат, төсвийн өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн мэдээлэл, 6.4.8 .... Авлага үүсгэсэн шийдвэрийн тоо) заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:



/Б.ТЭГШДЭЛГЭР/

3.18

АХЛАХ АУДИТОР



/Г.ЭРДЭНЭЧИМЭГ/

3.15

БИЗКОН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

/Л.ОТГОНБАЯР/

БОЛОВСРУУЛСАН:



БИЗКОН АУДИТ ХХК-ЫН АУДИТОР



/Ч.МӨНХБАЯР/

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж			
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																		
1.	Хөвсгөл ус суваг ХХК	ХӨА-2022/20/НА-СТА-ОНА	Мөнгөн гүйлгээний тайлан дахь үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн мөнгө, санхүүгийн тайлангийн тодруулгын худалдан авсан үндсэн хөрөнгийн дүнгээс зөрүүтэй тайлагнасан	Тайлант онд 277.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй бөгөөд хугацаа хэтэрсэн авлага байхгүй байна. Байгууллага иргэдээс авах 14.8 сая төгрөгийн авлагыг тооцооны үлдэгдлээр баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бортгалийн тухай хуулийн 20.2.6.эд, хөрөнгийн байгууллагатай шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан үлдэгдлийг авалчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах байгуулах удирдаж эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.	1	90.6	1	90.6										
2.	Хөвсгөл ус суваг ХХК	ХӨА-2022/20/НА-СТА-ОНА	Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх 75 мэдээллээс 64 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Хуулийн (6.8.1 Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, бусад санхүүгийн хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн туншлэлийн гэрээ концесс, засгийн газар оронжуулын (6.8.1, 6.4.8 нутгийн батлалаат, төсвийн өр, авлааг... Авлага үүсгэсэн үүсгэсэн авлааг шийдвэрийн тоо-мин 945.6 сая) Авлааг үүсгэсэн шийдвэрийн тоо-мин 945.6 сая) мэдээлэгч хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.	1	14.8											1	14.8	
3.	Хөвсгөл ус суваг ХХК	ХӨА-2022/20/НА-СТА-ОНА	Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх 75 мэдээллээс 64 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Хуулийн (6.8.1 Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, бусад санхүүгийн хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн туншлэлийн гэрээ концесс, засгийн газар оронжуулын (6.8.1, 6.4.8 нутгийн батлалаат, төсвийн өр, авлааг... Авлага үүсгэсэн үүсгэсэн авлааг шийдвэрийн тоо-мин 945.6 сая) Авлааг үүсгэсэн шийдвэрийн тоо-мин 945.6 сая) мэдээлэгч хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.	1	945.6											1	945.6	
					3	1051.0	1	90.6								2	960.4	